

ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ
СТАТИСТИК ТАНДАЛТ СУДАЛГААНЫ АЛБА



2023

2023 ОНЫ ОСОЛ ГЭМТЛИЙН ТАНДАЛТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот, 2024 он

Хянасан:

Б.Түмэн-Өлзий /СТСАлбаны дарга,
Мэдээлэл зүйн мэргэжилтэн/

Тайлан боловсруулсан:

СТСАлбаны:

А.Жаргалмаа /Эпидемиологич/

Б.Баянзул /НЭМ-ийн мэргэжилтэн/

Г.Цэрэн /Эпидемиологич/

Э.Анубүжин /Эпидемиологич/

А.Ариунцэцэг /НЭМ-ийн мэргэжилтэн/

ГАРЧИГ

- Товчилсон үгийн жагсаалт
- Үзүүлэлт тооцох аргачлал

БҮЛЭГ 1

- 2023 оны осол гэмтлийн шалтгаант өвчлөлийн байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 2

- 2023 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын байдалд хийгдсэн дүн шинжилгээ

БҮЛЭГ 3

- Харилцагч эрүүл мэндийн байгууллагуудын тандалтын мэдээ, тайлангийн үнэлгээ
- Осол гэмтлийн шалтгаант өвчлөл, нас баралтын бүртгэл, цахим мэдээний сан, сарын мэдээ, жилийн эцсийн тайлантай холбоотой анхаарах зүйлс, нийтлэг гарч буй хүндрэл, алдааны тухай

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГССҮТ	Гэмтэл согог судлалын үндэсний төв
СТСА	Статистик тандалт судалгааны алба
ЭМХТ	Эрүүл мэндийн хөгжлийн төв
НЭМГ	Нийслэлийн эрүүл мэндийн газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
УГТЭ	Улсын гуравдугаар төв эмнэлэг
СЭМҮТ	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
МЯСЭ	Монгол-Японы сургалтын эмнэлэг
ЦТЭ	Цэргийн төв эмнэлэг
ТЗНЭ	Төмөр замын нэгдсэн эмнэлэг
ТТАХНЭ	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг
ХАЯТТ	Хүлээн авах яаралтай тусламжийн тасаг
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв
БГДЭМТ	Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв
БЗДНЭМТ	Баянзүрх дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
СХДНЭМТ	Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
СБДНЭМТ	Сүхбаатар дүүргийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв
ХУДЭМТ	Хан уул дүүргийн эрүүл мэндийн төв
ЧДЭМТ	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв
НДЭМТ	Налайх дүүргийн эрүүл мэндийн төв
БндЭМТ	Багануур дүүргийн эрүүл мэндийн төв
БхдЭМТ	Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв

ҮЗҮҮЛЭЛТ ТООЦСОН АРГАЧЛАЛ

1. Осол гэмтлийн өвчлөлийн тохиолдлын түвшинг (ТТ) тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шинэ тохиолдлын тоог тухайн жилийн дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
2. Осол гэмтлийн тархалтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд осол гэмтлийн шалтгаанаар эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлын тоог тухайн жилийн дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
3. Осол гэмтлийн шалтгаан тус бүрийн өвчлөлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн (ӨОУА-10 дагуу осол гэмтлийн шалтгаан тус бүрээр) осол гэмтлийн шинэ өвчлөлийн тоог тухайн жилийн дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
4. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тухайн жилийн дундаж хүн амын тоонд харьцуулан, 10 000 хүн тутамд тооцсон.
5. Осол гэмтлийн үхлийн түвшинг тооцохдоо тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтын тохиолдлын тоог тайлангийн жилд бүртгэгдсэн осол гэмтлийн өвчлөлийн тоонд харьцуулан, 1 000 гэмтэл тутамд тооцсон.
6. Осол гэмтлийн шалтгаан бүрт нас баралтын түвшинг тооцохдоо тайлангийн жилд тухайн шалтгаанаар бүртгэгдсэн нас баралтыг тухайн жилийн дундаж хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.
7. Осол гэмтлийн шалтгаант нас баралтын болон өвчлөлийн тархалтыг харуулахдаа тухайн аймаг, дүүрэгт бүртгэгдсэн тохиолдлыг тухайн аймаг дүүргийн хүн амд харьцуулан, 10 000 хүн амд тооцсон.



I БҮЛЭГ



**2023 оны осол гэмтлийн
шалтгаант өвчлөлийн байдалд
хийсэн дүн шинжилгээ**

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛИЙН БАЙДАЛ 2023 ОН

1. Ерөнхий хэсэг


2023 онд Монгол улсын хэмжээнд 210 763 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 11.6 хувиар өсөж хамгийн их тохиолдолтой жил болсон байна. Манай улсын 10 000 хүн тутамд ногдох тохиолдлын түвшин 609.6 байна.

Жич: 2023 оны хүн амын үзүүлэлт жилийн эцсийн хүн ам биш болно. Тухайн үзүүлэлт 2024 оны 4 сард гарах ба одоогийн үзүүлэлтийг 2022 хүн амаар тооцов./




Нийт тохиолдлын 59.7% эрэгтэй, 40.3% эмэгтэй байна. Өөрөөр хэлбэл осол гэмтлийн шалтгаант 10 шинэ тохиолдол тутмын 6 нь эрэгтэй, 4 нь эмэгтэй байна.


2023 онд тохиолдлын түвшин эрэгтэйд 741.3 болж өмнөх оноос 71.5 тохиолдлоор, эмэгтэйд 382.7 байгаа нь өмнөх оноос 55.2 тохиолдлоор тус тус нэмэгдсэн байна. Осол гэмтлийн өвчлөлд эрчүүд эмэгтэйчүүдээс 1.5 дахин их өртөж байна.



Тохиолдлын тоогоор 0-4 насныхан хамгийн их байгаа бол тухайн насны 10 000 хүн тутамд ногдох тохиолдлын түвшин 15-19 насанд бусад насны бүлэгтэй харьцуулахад өндөр байна.




Осол гэмтлийн шинэ тохиолдлын тоо эрэгтэй, эмэгтэй аль ч хүйсэнд 0-4 насанд (эрэгтэй 11.1%, эмэгтэй 13.5%) хамгийн өндөр байгаа бол 65-69 (2.0%) насанд хамгийн бага бүртгэгдсэн байна.



Жилд дунджаар 20 000 хүн согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ гэмтэж, энэ нь тухайн жилийн 10 гаруй хувийг эзэлж байна.

Үзүүлэлт	2021		2022		2023	
	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь	Бодит тоо	Хувь
Нийт тохиолдлын тоо	142442		188916		210763	
Үүнээс согтууруулах ундаа хэрэглэсэн	12751	9.0	21808	11.5	23217	11.0

2023 ОНЫ ОСОЛ ГЭМТЛИЙН ШИНЭ ТОХИОЛДЛЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН



Бүх насны бүлэгт унаж гэмтэх шалтгаан тэргүүлж байна. Түлэгдэлтийн шалтгаан 0-4 насанд тэргүүлэх шалтгааны гуравдугаарт байгаа бол бусад насанд амьгүй механик хүчинд өртөх, зам тээврийн осол, амьтай механик хүчинд өртөх болон хүчирхийллийн шалтгаанаар гэмтэх нь түгээмэл байна.

Насны бүлэг	Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
0-4	Уналт 45.0%	Амьд механик хүчинд өртөх 16.9%	Түлэгдэлт 13.0%	Амьгүй механик хүчинд өртөх 12.3%	Тодорхойгүй осол 7.5%
5-9	Уналт 55.3%	Амьгүй механик хүчинд өртөх 13.6%	Амьд механик хүчинд өртөх 12.2%	Зам тээврийн осол 9.2%	Тодорхойгүй осол 3.8%
10-14	Уналт 54.1%	Амьгүй механик хүчинд өртөх 14.7%	Амьд механик хүчинд өртөх 11.5%	Зам тээврийн осол 10.8%	Хүчирхийлэл 4.2%
15-19	Уналт 45.8%	Амьгүй механик хүчинд өртөх 18.0%	Зам тээврийн осол 13.4%	Амьд механик хүчинд өртөх 9.1%	Хүчирхийлэл 8.2%
20-24	Уналт 35.4%	Амьгүй механик хүчинд өртөх 20.9%	Хүчирхийлэл 14.9%	Зам тээврийн осол 14.0%	Амьд механик хүчинд өртөх 6.8%
25-29	Уналт 34.5%	Амьгүй механик хүчинд өртөх 20.5%	Хүчирхийлэл 17.2%	Зам тээврийн осол 13.5%	Амьд механик хүчинд өртөх 5.7%
30-34	Уналт 35.6%	Амьгүй механик хүчинд өртөх 20.3%	Хүчирхийлэл 16.9%	Зам тээврийн осол 12.0%	Амьд механик хүчинд өртөх 5.3%
35-39	Уналт 35.1%	Амьгүй механик хүчинд өртөх 19.8%	Хүчирхийлэл 15.7%	Зам тээврийн осол 13.1%	Амьд механик хүчинд өртөх 4.9%
40-44	Уналт 37.0%	Амьгүй механик хүчинд өртөх 17.9%	Зам тээврийн осол 13.8%	Хүчирхийлэл 13.4%	Амьд механик хүчинд өртөх 5.3%
45-49	Уналт 40.0%	Амьгүй механик хүчинд өртөх 16.8%	Зам тээврийн осол 14.2%	Хүчирхийлэл 10.8%	Амьд механик хүчинд өртөх 5.2%
50-54	Уналт 45.2%	Амьгүй механик хүчинд өртөх 14.9%	Зам тээврийн осол 13.1%	Хүчирхийлэл 8.8%	Амьд механик хүчинд өртөх 5.1%
55-59	Уналт 51.2%	Зам тээврийн осол 13.2%	Амьгүй механик хүчинд өртөх 12.5%	Хүчирхийлэл 6.6%	Амьд механик хүчинд өртөх 5.1%
60-64	Уналт 55.4%	Зам тээврийн осол 11.9%	Амьгүй механик хүчинд өртөх 10.7%	Амьд механик хүчинд өртөх 5.9%	Хүчирхийлэл 4.8%
65-69	Уналт 61.3%	Зам тээврийн осол 10.4%	Амьгүй механик хүчинд өртөх 9.8%	Амьд механик хүчинд өртөх 4.9%	Тодорхойгүй осол 3.7%
70	Уналт 73.6%	Амьгүй механик хүчинд өртөх 6.2%	Зам тээврийн осол 6.1%	Амьд механик хүчинд өртөх 4.1%	Тодорхойгүй осол 4.0%


Осол гэмтэлд өртсөн тохиолдлын **23.0%** нь толгойн гэмтлийн оноштой бол 32.0% нь дээд мөчдийн гэмтэл, 25.8% нь доод мөчдийн гэмтлийн оноштой байна.

Гэмтсэн эрхтний байршил	Тоо	Хувь
Толгойн гэмтэл S00-S09	48362	23.0
Хүзүүний гэмтэл S10-S19	1860	0.9
Цээжний гэмтэл S20-S29	11968	5.7
Хэвлийн гэмтэл S30-S39	11049	5.2
Мөр ба бугалганы гэмтэл S40-S49	11452	5.4
Тохой ба шууны гэмтэл S50-S59	29596	14.0
Бугуй ба сарвууны гэмтэл S60-S69	26521	12.6
Түнх ба гуяны гэмтэл S70-S79	7221	3.4
Өвдөг ба шилбэний гэмтэл S80-S89	21030	10.0
Шагай ба тавхайн гэмтэл S90-S99	26130	12.4
Биеийн олон хэсгийн гэмтэл T00-T09	521	0.3
Түлэгдэлт T20-T32	7134	3.4
Хөлдөлт T33-T35	728	0.4
Бусад болон тодорхойгүй хэсгийн гэмтэл T10-T14	258	0.1
Биеийн сүвээр орсон гадны биет T15-T19	1393	0.7
Эм, эмийн бэлдмэлийн хордлого T36-T50	316	0.2
Эмийн бус бэлдмэлийн хордлого T51-T65	3643	1.7
Бусад тодорхойгүй нөлөөлөл T66-T78	1196	0.6
Хүндрэл T90-T99	385	0.2


Осол гэмтлийн тэргүүлэх шалтгаан бүрт ямар эрхтэн илүү гэмтсэн байгааг авч үзэхэд зам тээврийн ослын үед зөөлөн эдийн болон гавал доторх гэмтэл, унаж гэмтэх үед зөөлөн эдийн гэмтэл, амьгүй болон амьтай механик хүчинд өртөх, хүчирхийллийн шалтгааны үед шархны онош тэргүүлсэн байна.

Осол гэмтлийн шалтгаан	Гэмтлийн онош				
	I	II	III	IV	V
Зам тээврийн осол (V01-V99)	Зөөлөн эдийн гэмтэл 31.8%	Гавал доторх гэмтэл 28.1%	Хугарал 22.8%	Шарх 8.3%	Мултрал суналт 3.9%
Уналт (W00-W19)	Зөөлөн эдийн гэмтэл 42.4%	Хугарал 27.3%	Мултрал суналт 12.6%	Шарх 8.7%	Гавал доторх гэмтэл 7.6%
Амьгүй механик хүчинд өртөх (W20-W49)	Шарх 43.4%	Зөөлөн эдийн гэмтэл 28.8%	Хугарал 12.3%	Гавал доторх гэмтэл 5.4%	Биеийн сүвүүдээр орсон гадны биет 3.7%
Амьтай механик хүчинд өртөх (W50-W64)	Шарх 35.3%	Зөөлөн эдийн гэмтэл 25.2%	Мултрал суналт 21.5%	Хугарал 12.2%	Гавал доторх гэмтэл 4.8%
Дайралт, халдлага /Хүчирхийлэл/ (X85-Y09)	Шарх 30.8%	Гавал доторх гэмтэл 25.3%	Зөөлөн эдийн гэмтэл 22.4%	Хугарал 17.3%	Мултрал суналт 1.3%


Осол гэмтлийн шинэ тохиолдлын **28.2%** зун, 25.9% хавар, 25.2% намар, 20.7% өвлийн улиралд бүртгэгдсэн байна.



2023 онд осол гэмтлийн шалтгаант өвчлөл 5, 6, 7 саруудад хамгийн их /28.4%/, 1, 2, /13.2%/ саруудад хамгийн бага бүртгэгдсэн байна.



2023 онд бүртгэгдсэн нийт осол гэмтлийн тохиолдлын 178277 буюу 84.6% нийслэлд 34486 тохиолдол буюу 15.4% орон нутагт бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл нийслэлийн 10000 хүн тутмын 1053.8 нь, орон нутгийн 10000 хүн тутмын 195.3 тохиолдол осол гэмтэлд өртөж байна.




Тохиолдлын тоогоор Архангай, Дорноговь, Төв, Дархан-Уул, Өвөрхангай аймгууд тэргүүлсэн бол тухайн газар нутгийн 10000 хүн ам тутамд ногдох тохиолдлын түвшин Дорноговь, Архангай, Говьсүмбэр, Төв, Хэнтий аймгуудад өндөр, Ховд, Орхон аймагт хамгийн бага байна.




Тухайн аймагт тэргүүлж буй осол гэмтлийн шалтгааныг харвал Дундговь, Төв, Увс аймгуудад зам тээврийн осол, Өмнөговь аймагт амьгүй механик хүчинд өртөх шалтгаан тэргүүлсэн бол бусад аймагт уналтын шалтгаан зонхилон тохиолдож зам тээврийн осол 2-рт байна.

Аймгийн нэр	Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
Архангай	Уналт 25.0%	ЗТО 23.7%	Амьгүй м/х өртөх 17.2%	Хүчирхийлэл 11.9%	Амьтай м/х өртөх 9.3%
Баян-Өлгий	Уналт 42.9%	ЗТО 23.9%	Амьгүй м/х өртөх 12.7%	Хүчирхийлэл 6.8%	Түлэгдэлт 4.6%
Баянхонгор	Уналт 30.3%	ЗТО 24.7%	Санамсаргүй хордолт 15.7%	Хүчирхийлэл 9.3%	Амьгүй м/х өртөх 7.0%
Булган	Уналт 29.0%	ЗТО 28.8%	Амьгүй м/х өртөх 16.4%	Амьтай м/х өртөх 7.2%	Түлэгдэлт 6.3%
Говь-Алтай	Уналт 27.4%	ЗТО 23.5%	Амьгүй м/х өртөх 14.9%	Хүчирхийлэл 11.9%	Амьтай м/х өртөх 8.9%
Говьсүмбэр	Уналт 26.0%	ЗТО 25.3%	Амьгүй м/х өртөх 17.4%	Хүчирхийлэл 13.9%	Амьтай м/х өртөх 9.3%
Дархан-уул	Уналт 34.9%	Амьгүй м/х өртөх 19.9%	Хүчирхийлэл 18.2%	ЗТО 15.7%	Амьтай м/х өртөх 4.2%
Дорноговь	Уналт 35.5%	Амьгүй м/х өртөх 22.0%	ЗТО 17.0%	Хүчирхийлэл 12.5%	Амьтай м/х өртөх 4.4%
Дорнод	Уналт 38.4%	ЗТО 18.9%	Амьгүй м/х өртөх 19.0%	Хүчирхийлэл 9.0%	Түлэгдэлт 7.0%
Дундговь	ЗТО 36.7%	Уналт 21.1%	Хүчирхийлэл 15.1%	Амьгүй м/х өртөх 10.4%	Амьтай м/х өртөх 6.9%
Завхан	Уналт 29.9%	ЗТО 24.0%	Хүчирхийлэл 15.5%	Амьгүй м/х өртөх 14.8%	Амьтай м/х өртөх 8.6%
Орхон	Уналт 46.3%	ЗТО 19.9%	Амьгүй м/х өртөх 13.3%	Түлэгдэлт 6.5%	Хүчирхийлэл 5.5%
Өвөрхангай	Уналт 31.9%	Амьгүй м/х өртөх 30.3%	ЗТО 15.2%	Амьтай м/х өртөх 6.8%	Хүчирхийлэл 5.4%
Өмнөговь	Амьгүй м/х өртөх 35.5%	ЗТО 20.8%	Уналт 16.9%	Хүчирхийлэл 13.6%	Түлэгдэлт 5.7%
Сүхбаатар	Уналт 31.4%	ЗТО 26.9%	Хүчирхийлэл 11.7%	Амьгүй м/х өртөх 8.4%	Амьтай м/х өртөх 7.2%
Сэлэнгэ	Уналт 25.4%	ЗТО 20.9%	Хүчирхийлэл 18.2%	Амьгүй м/х өртөх 16.6%	Амьтай м/х өртөх 6.3%
Төв	ЗТО 32.7%	Амьгүй м/х өртөх 15.6%	Уналт 21.8%	Хүчирхийлэл 11.4%	Амьтай м/х өртөх 6.6%
Увс	ЗТО 29.8%	Уналт 23.9%	Амьгүй м/х өртөх 16.5%	Хүчирхийлэл 9.3%	Түлэгдэлт 7.9%
Ховд	Уналт 40.8%	ЗТО 28.7%	Амьгүй м/х өртөх 9.2%	Амьтай м/х өртөх 5.9%	Түлэгдэлт 5.6%
Хөвсгөл	Уналт 28.6%	ЗТО 24.6%	Амьгүй м/х өртөх 17.0%	Хүчирхийлэл 13.5%	Түлэгдэлт 5.0%
Хэнтий	Уналт 27.4%	ЗТО 21.7%	Амьгүй м/х өртөх 17.5%	Хүчирхийлэл 14.2%	Амьтай м/х өртөх 8.0%
Улаанбаатар	Уналт 47.6%	Амьгүй м/х өртөх 15.8%	ЗТО 9.0%	Амьтай м/х өртөх 8.8%	Хүчирхийлэл 8.2%

Осол гэмтэлд өртөх үеийн байршлаар харвал 35.6% гэртээ, 30.5% гудамж замд гэмтсэн байгаа бол үлдсэн хувийг биеийн тамир спортын талбай, тоглоомын талбай, хөдөө, олон нийтийн болон худалдаа үйлчилгээний газар, барилга, үйлдвэрлэл, уурхай зэрэг газрууд эзэлж байна.




Нийт тохиолдлын 91.2% нь эрүүл мэндийн байгууллагад өөрөө, 7.3% нь түргэн тусламжаар, 1.5% нь такси болон бусад аргаар эмнэлэгт ирсэн байна.




1.2 УНАЛТЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /W00-W19/


2023 онд уналтын шалтгаанаар бэртэж гэмтэх тохиолдол 94,550 бүртгэгдсэн ба өмнөх онтой харьцуулахад 11.8%-р өссөн байна. Тохиолдлын тоог хүн амын тоотой харьцуулан тооцоолоход 10 000 хүн тутмын 273.5 нь тухайн шалтгааны улмаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан байна.




Уналтын шалтгаант осол гэмтлийг хүйсээр авч үзэхэд 53.1% нь эрэгтэй, 46.9% нь эмэгтэй байна.



Насны бүлгээр авч үзэхэд тохиолдлын тоогоор 10-14 насанд бусад насны бүлгээс өндөр /12,698/ үзүүлэлттэй байгаа бол 10 000 хүн амд тооцож үзэхэд 70-аас дээш насныханд хамгийн өндөр буюу тухайн насны 10 000 хүн тутамд 457.5 нь уналтын шалтгаанаар бэртэж гэмтсэн байна.



ӨОУА 10-ын дагуу уналтын шалтгааныг дотор нь хувааж үзвэл дараах 5 шалтгаан тэргүүлж байгаа ба W01 буюу нэг түвшин дээр халтирч, тээглэж бүдэрч унах шалтгаан /55.3%/ түгээмэл тохиолдож байна.




2023 онд унаж гэмтсэний улмаас тусламж үйлчилгээ авсан нийт тохиолдлыг гэмтлийн байршлаар авч үзэхэд шагай ба тавхайн гэмтэл 20.2% /19059/, тохой ба шууны гэмтэл 18.1% /17069/, тархины гэмтэл 16.8% /15864/, өвдөг ба шилбэний гэмтэл 13.6% /12833/-р оношлогдох тохиолдол тус тус тэргүүлж байна.


Гэмтлийн байршил	2023	
	Бодит тоо	Хувь
Шагай ба тавхайн гэмтэл /S90-S99/	19,059	20.2
Тохой ба шууны гэмтэл /S50-S59/	17,069	18.1
Тархины гэмтэл /S00-S09/	15,864	16.8
Өвдөг ба шилбэний гэмтэл /S80-S89/	12,833	13.6
Бугуй ба сарвууны гэмтэл /S60-S69/	7,017	7.4
Мөр ба бугалганы гэмтэл /S40-S49/	6,457	6.8
Хэвлийн гэмтэл /S30-S39/	6,050	6.4
Цээжний гэмтэл /S20-S29/	5,600	5.9
Түнх ба гуяны гэмтэл /S70-S79/	3,766	4.0
Хүзүүний гэмтэл /S10-S19/	540	0.6
Биеийн олон хэсгийн гэмтэл /T00-T09/	146	0.2
Хүндрэл /T79-T88/	99	0.1
Бусад тодорхойгүй хэсгийн гэмтэл /T10-T14/	50	0.1
Нийт	94,550	100

Унаж бэртэх үед зөөлөн эд гэмтэх нь хамгийн түгээмэл /42.4%/ тохиолдож байгаа ба хугарал /27.3%, мултрал ба суналт /12.6%/, шарх /8.7%/, гавал доторх гэмтэл /7.6%/ зэргүүд тэргүүлж байна.

Гэмтлийн төрөл	2023	
	Бодит тоо	Хувь
Зөөлөн эдийн гэмтэл	40,122	42.4
Хугарал	25,780	27.3
Мултрал, суналт	11,904	12.6
Шарх	8,237	8.7
Гавал доторх гэмтэл	7,154	7.6
Шөрмөсний гэмтэл	448	0.5
Бусад тодорхойгүй гэмтэл	404	0.4
Мэдрэлийн гэмтэл	143	0.2
Хүндрэл	99	0.1
Хэвлийн хөндийн гэмтэл	93	0.1
Цээж доторх гэмтэл	74	0.1
Эд эрхтэн бяцрах	32	0.0
Судасны гэмтэл	31	0.0
Аарцгийн хөндийн гэмтэл	15	0.0
Эд эрхтэн тайрагдах	14	0.0
Нийт	94,550	100


Уналтын шалтгаант осол гэмтлийг гарсан байршлаар авч үзэхэд ихэвчлэн гэртээ /хашаандаа/ унаж бэртсэн гэсэн өгүүлэмжтэй байгаа ба гудамж зам, спорт заал, сургууль цэцэрлэг дээрээ унаж бэртэх тохиолдлууд мөн өндөр хувийг эзлэж байна.






2023 оны уналтын шалтгаант нийт өвчлөл зуны улиралд /6, 7, 8 сар/ хамгийн их /26.1%/ тохиолдсон байна.

Харин шинэ тохиолдлыг сараар авч үзвэл 6-р сард бусад саруудаас өндөр буюу 8,593 /9.1%/ тохиолдол бүртгэгдсэн байна.




Уналтын шалтгаант шинэ тохиолдол даваа гарагт /15.4%/ бусад өдрүүдтэй харьцуулахад өндөр бүртгэгдсэн байна.





Уналтын шалтгаант шинэ тохиолдолын 89.8% нь нийслэлд бүртгэгдсэн байна. Өөрөөр хэлбэл уналтын шалтгаанаар бэртэж, тусламж үйлчилгээ авч буй 10 хүн тутмын 9 нь нийслэлд 1 нь орон нутагт бүртгэгджээ.


Уналтын шалтгаант осол гэмтлийн шинэ тохиолдол төвийн бүсэд бусад бүс нутгаас өндөр бүртгэгдсэн ба Дорноговь аймагт бусад аймгуудын дунджаас өндөр байна.




1.2 АМЬГҮЙ МЕХАНИК ХҮЧИНД ӨРТӨХ ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /W20-W49/

2023 онд Амьгүй механик хүчинд өртөж гэмтэх шалтгаант 34000 тохиолдол бүртгэгдсэн ба энэ нь тухайн жилийн нийт осол гэмтлийн шинэ тохиолдлын 16.1%-ийг эзэлж байна. 2022 оноос 2023 онд 11.9% хувиар өссөн үзүүлэлттэй байна. Монгол улсын 10.000 хүн ам тутамд 98 хүн амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн байна.

Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл 10000 хүн амд, өсөлтийн хувь, оноор



Эмэгтэй
32.4




Эрэгтэй
67.8


Амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн тохиолдлын 67.8% эрэгтэй /22979/, 32.4% эмэгтэй /5766/ байна.

2023 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөлийн тохиолдлын тоо болон тохиолдлын түвшин 30-34 насанд бусад наснаас өндөр байна.


Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл насны бүлгээр



Тэргүүлэх 5 шалтгаан



Амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн нийт тохиолдлын 43.1% бугуй ба сарвууны, 19.0% тархи, 9.2% тохой ба шуу гэмтсэн тохиолдлууд өндөр байна.




Амьгүй механик хүчинд өртөх шалтгааны улмаас аль ч насанд бусад зүйл мөргөх буюу цохигдох шалтгаан тэргүүлж байна.

Насны бүлэг	Амьгүй механик хүчинд өртөх тэргүүлэх шалтгаан 2023 он				
	I	II	III	IV	V
0-4 n=3108	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 4.4%	Хоёр юмны хооронд хавчигдах 1.6%	Шидээдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 1.0%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 0.6%	Хурц шилэнд зүсээгдэх 0.5%
5-9 n=2572	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 44.6%	Хоёр юмны хооронд хавчигдах 13.5%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 10.1%	Шидээдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 9.7%	Хурц шилэнд зүсээгдэх 6.8%
10-14 n=3448	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 39.3%	Спортын хэрэгсэл мөргөх буюу цохигдох 22.4%	Хурц шилэнд зүсээгдэх 7.3%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 6.9%	Шидээдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 6.5%
15-19 n=3194	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 32.9%	Спортын хэрэгсэл мөргөх буюу цохигдох 13.7%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 10.2%	Шидээдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 10.1%	Хурц шилэнд зүсээгдэх 8.8%
20-24 n=3249	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 25.6%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 15.1%	Хурц шилэнд зүсээгдэх 13.0%	Шидээдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 11.0%	Хутганд өртөх 9.7%
25-29 n=3095	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 21.8%	Хурц шилэнд зүсээгдэх 13.3%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 13.3%	Шидээдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 12.2%	Хутганд өртөх 11.3%
30-34 n=3710	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 24.0%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 12.4%	Шидээдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 11.3%	Хурц шилэнд зүсээгдэх 11.2%	Хутганд өртөх 11.1%
35-39 n=3305	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 23.4%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 12.6%	Шидээдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 12.0%	Хутганд өртөх 10.0%	Хурц шилэнд зүсээгдэх 9.8%
40-44 n=2374	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 22.9%	Шидээдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 12.6%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 11.5%	Хутганд өртөх 10.8%	Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж, хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд өртөх 10.7%

45-49 n=1928	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 22.8%	Шидээгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 11.4%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 11.3%	Хутганд өртөх 10.7%	Хоёр юмны хооронд хавчигдах 9.1%
50-54 n=1472	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 22.8%	Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж, хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд өртөх 15.5%	Шидээгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 11.6%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 11.1%	Хутганд өртөх 8.9%
55-59 n=1052	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 23.6%	Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж, хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд өртөх 14.6%	Шидээгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 12.4%	Хутганд өртөх 10.6%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 10.0%
60-64 n=739	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 25.4%	Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж, хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд өртөх 16.9%	Шидээгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 13.4%	Хоёр юмны хооронд хавчигдах 9.9%	Хутганд өртөх 9.1%
65-69 n=404	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 22.8%	Бусад хөдөлгүүртэй хөдөлмөрийн багаж, хэрэгсэл, гэр ахуйн төхөөрөмжинд өртөх 14.1%	Шидээгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 12.6%	Хоёр юмны хооронд хавчигдах 12.1%	Хутганд өртөх 10.1%
70+ n=350	Бусад зүйл мөргөх буюу цохигдох 35.3%	Хоёр юмны хооронд хавчигдах 12.5%	Хутганд өртөх 10.5%	Шидээгдсэн, нурсан, унасан зүйлд цохиулах 8.8%	Өргөх ба дамжуулах төхөөрөмж, хэрэгсэлтэй хүрэлцэж гэмтэх 6.8%


Амьгүй механик хүчинд өртөж гэмтэж гэмтсэн тохиолдол оношийн бүлэг, насны бүлгээр харахад аль ч насанд бугуй ба сарвууны гэмтэл, тархины гэмтэл тэргүүлж байна.

Насны бүлэг	Гэмтэлийн байршил тэргүүлэх шалтгаан				
	I	II	III	IV	V
0-4 /3108/	Тархины гэмтэл 47.6%	Бугуй ба сарвууны гэмтэл 26.9%	Шагай ба тавхайн гэмтэл 7.8%	Биеийн сүвээр орсон гадны биет 4.9%	Тохой ба шууны гэмтэл 4.8%
5-9 /2572/	Тархины гэмтэл 37.5%	Бугуй ба сарвууны гэмтэл 27.2%	Шагай ба тавхайн гэмтэл 11.9%	Тохой ба шууны гэмтэл 6.4%	Өвдөг, шилбэний гэмтэл 6.4%
10-14 /3448/	Бугуй ба сарвууны гэмтэл 48.7%	Тархины гэмтэл 17.0%	Шагай ба тавхайн гэмтэл 10.9%	Тохой ба шууны гэмтэл 10.3%	Өвдөг, шилбэний гэмтэл 5.2%
15-19 /3194/	Бугуй ба сарвууны гэмтэл 53.8%	Тархины гэмтэл 14.4%	Тохой ба шууны гэмтэл 9.8%	Шагай ба тавхайн гэмтэл 8.9%	Өвдөг, шилбэний гэмтэл 5.3%
20-24 /3249/	Бугуй ба сарвууны гэмтэл 50.8%	Тархины гэмтэл 13.0%	Тохой ба шууны гэмтэл 11.3%	Шагай ба тавхайн гэмтэл 9.7%	Өвдөг, шилбэний гэмтэл 5.0%
25-29 /3095/	Бугуй ба сарвууны гэмтэл 49.2%	Тархины гэмтэл 12.4%	Тохой ба шууны гэмтэл 11.2%	Шагай ба тавхайн гэмтэл 10.1%	Өвдөг, шилбэний гэмтэл 4.7%
30-34 /3710/	Бугуй ба сарвууны гэмтэл 45.6%	Тархины гэмтэл 14.0%	Шагай ба тавхайн гэмтэл 10.6%	Тохой ба шууны гэмтэл 10.1%	Өвдөг, шилбэний гэмтэл 5.5%
35-39 /3305/	Бугуй ба сарвууны гэмтэл 45.6%	Тархины гэмтэл 13.7%	Шагай ба тавхайн гэмтэл 11.3%	Тохой ба шууны гэмтэл 8.2%	Өвдөг, шилбэний гэмтэл 5.8%
40-44 /2374/	Бугуй ба сарвууны гэмтэл 41.7%	Тархины гэмтэл 13.7%	Шагай ба тавхайн гэмтэл 11.5%	Тохой ба шууны гэмтэл 9.3%	Өвдөг, шилбэний гэмтэл 6.5%
45-49 /1928/	Бугуй ба сарвууны гэмтэл 42.1%	Тархины гэмтэл 14.7%	Тохой ба шууны гэмтэл 9.8%	Шагай ба тавхайн гэмтэл 9.5%	Өвдөг, шилбэний гэмтэл 6.7%
50-54 /1472/	Бугуй ба сарвууны гэмтэл 40.3%	Тархины гэмтэл 14.6%	Шагай ба тавхайн гэмтэл 9.9%	Тохой ба шууны гэмтэл 9.8%	Өвдөг, шилбэний гэмтэл 7.1%
55-59 /1052/	Бугуй ба сарвууны гэмтэл 40.7%	Шагай ба тавхайн гэмтэл 12.5%	Тархины гэмтэл 12.3%	Тохой ба шууны гэмтэл 8.7%	Цээжний гэмтэл 6.1%
60-64 /739/	Бугуй ба сарвууны гэмтэл 38.0%	Тархины гэмтэл 14.5%	Шагай ба тавхайн гэмтэл 10.6%	Тохой ба шууны гэмтэл 8.3%	Өвдөг, шилбэний гэмтэл 6.9%
65-69 /404/	Бугуй ба сарвууны гэмтэл 35.6%	Тархины гэмтэл 13.6%	Шагай ба тавхайн гэмтэл 12.4%	Тохой ба шууны гэмтэл 10.4%	Биеийн сүвээр орсон гадны биет 8.2%
70 /350/	Бугуй ба сарвууны гэмтэл 35.0%	Тархины гэмтэл 17.1%	Цээжний гэмтэл 10.8%	Тохой ба шууны гэмтэл 10.0%	Шагай ба тавхайн гэмтэл 6.3%




2023 онд амьгүй механик хүчинд өртөх шалтгаанаар гэмтсэн тохиолдлыг улирлаар харахад хамгийн их нь зун 29.4% бүртгэгдсэн байна. Хавар 26.3%, намар 26.2% байгаа бөгөөд хамгийн бага нь өвөл 18.2% тухайн шалтгаанаар бүртгэгдсэн байна.


2023 онд орон нутагт бүртгэгдсэн амьгүй механик хүчинд өртөх шалтгаант осол гэмтэл Төвийн бүсэд /2501/, Дорноговь аймагт /696/ бусад аймгуудаас өндөр байна.




2023 оны нийт амьгүй механик хүчинд өртөх шалтгаанаар гэмтэж бүртгэгдсэн нийт тохиолдлыг сар тус бүрээр харахад 5 сар /10.4%/ бусад саруудаас хамгийн өндөр байна.




Тус шалтгааны улмаас гэмтэж бүртгэгдсэн нийт тохиолдлын 14.7% даваа болон бямба гарагт хамгийн өндөр бүртгэсэн байна.



Амьгүй механик хүчинд өртөх шалтгаанаар гэмтэж бүртгэгдсэн өвчлөлийг осол гарах үеийн байршлын хувиар авч үзэхэд 46.6% гэртээ, 13.2% гудамж, зам хамгийн өндөр байна.




2023 онд амьгүй механик хүчинд өртөж гэмтсэн нийт тохиолдлын 5.0% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тухайн шалтгаанаар гэмтсэн байна.





2023 онд орон нутагт бүртгэгдсэн амьгүй механик хүчинд өртөх шалтгаант осол гэмтэл Төвийн бүсэд /2501/, Дорноговь аймагт /696/ бусад аймгуудаас өндөр байна.

Амьгүй механик хүчинд өртөх шалтгаант өвчлөл бүртгэгдсэн бүсээр




1.3 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ ӨВЧЛӨЛ /2023/

2023 онд зам тээврийн ослын шалтгаант шинэ тохиолдол 23548 бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 11.5% иар өссөн үзүүлэлттэй байна. Зам тээврийн осол нь осол гэмтлийн тэргүүлэх шалтгааны нэг ба 2023 онд 10 000 хүн тутмын 68.1 нь энэхүү осолд өртсөн үзүүлэлттэй байна.



2023 оны зам тээврийн ослын шалтгаант ослын нийт тохиолдлын 64.6% /15204/ эрэгтэй, 35.4% /8346/ эмэгтэйчүүд байна.


Тухайн онд зам тээврийн осолд өртөж гэмтсэн тохиолдол 10-14 насанд /2538/, тохиолдлын түвшин 15-19 насанд /101.8/ бусад наснаас өндөр байна. Өөрөөр хэлвэл 15-19 насны 10 000 хүүхэд тутмын 101.8 нь зам тээврийн осолд өртөж гэмтсэн байна.




ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН 2023





2023 онд зам тээврийн ослын шалтгаанаар гэмтсэн нийт тохиолдлын 39.8% буюу 9376 толгойн гэмтэл 11.5% буюу 2704 өвдөг шилбэний гэмтэл, 9.5% буюу 2246 цээжний гэмтлээр оношлогджээ.




Зам тээврийн осолд өртсөн нийт тохиолдлын 35.9% жолооч, 28.7% ийг зорчигч, 21.2% -г явган зорчигч эзэлж байгаа бол 14.0% нь морь мал унаж явсан байна.



Суудлын машинтай явж байгаад зам тээврийн осолд өртсөн тохиолдлын 23.7%-д, ачааны машинтай явж байсан тохиолдлын 18.2% нь суудлын хамгаалах бүстэй байсан гэсэн өгүүлэмжтэй байгаа бол мориноос унасан тохиолдлын 3.8%, мотоциклтой явж байгаад зам тээврийн осолд орох 8.7%, дугуйтай явж байгаад зам тээврийн осолд орсон тохиолдлын 6.8% нь хамгаалах малгай хэрэглэсэн байна.



Нийт тохиолдлын 8.3% нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртсөн байна.




2023 онд зам тээврийн осолд өртсөн нийт тохиолдлын 8.3% /1949/ нь согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртсөн байгаа ба тээврийн хэрэгслийн төрлөөр харвал мотоциклтой зорчигчийн согтуу үедээ осолд өртсөн хувь /15.6%/ бусад тээврийн хэрэгсэлтэй харьцуулахад өндөр байна.


Хүснэгт 1. Согтууруулах ундаа хэрэглэсэн байдал, тээврийн хэрэгслийн төрөл, хувь

Согтууруулах ундаа хэрэглэсэн эсэх	Тээврийн хэрэгслийн төрөл							
	V01-V09 (Явган)	V10-V19 (Дугуй)	V20-V39 (Мотоцикл)	V40-V49 (Суудлын машин)	V50-V69 (Ачааны машин)	V70-V79 (Нийтийн тээвэр)	V80-V80.9 (Морь)	V98 (Бусад)
	Хувиар							
Тийм	13.2	1.9	15.6	5.7	4.9	1	3.4	10.2
Үгүй	86.8	98.1	84.4	94.3	95.1	99	96.6	89.8


Улирлаас хамаарсан ялгаа ажиглагддаг осол гэмтлийн шалтгааны нэг нь зам тээврийн осол юм. 2023 оны зам тээврийн ослын шалтгаант шинэ тохиолдлын 38% нь зуны улиралд тохиолдсон байна.



Тухайн онд зам тээврийн осолд өртсөний улмаас эмнэлэгт хандах тохиолдол 7 сард /14.5%/ бусад саруудтай харьцуулахад өндөр байна.



2023 онд зам тээврийн осолд өртөх шалтгааны улмаас 7 хоногийн Даваа /15.8%/ гарагт харьцангуй их бүртгэгдсэн бөгөөд Пүрэв /13.4%/ гарагт хамгийн бага бүртгэгдсэн байна.



Нийт тохиолдлын 68.1% нь нийслэлд, 31.9% нь орон нутагт бүртгэгдсэн байгаа ба нийслэлд тохиолдлын түвшин орон нутгаас 2 дахин өндөр байна.

Хүснэгт 2. Зам тээврийн осол бүртгээгдсэн харъяаллаар, 10000 хүн амд

Бүртгэгдсэн газар	Шинэ тохиолдол		Тохиолдлын түвшин
	Бодит тоо	Хувь	
Нийслэл	16034	68.1%	94.8
Орон нутаг	7514	31.9%	42.6


Суудлын машины осол улсын дүнгээр тэргүүлж байна. Өмнөх онуудад орон нутагт мотоциклтой зорчигчийн осол тэргүүлж байсан бол 2023 онд 2-р шалтгаан болж байна. Явган явж байгаад зам тээврийн осолд орж гэмтэх тохиолдол нийслэл болон улсад эзлэх хувиар 2-рт байгаа бол орон нутагт 4-р шалтгаан болсон байна. Мөн эрүүл мэндийн салбарт онцлогоор бүртгэгддэг мориноос унаж гэмтэх тохиолдол орон нутагт 3-рт орж байна.

Хүснэгт 3. Зам тээврийн осол бүртгээгдсэн харъяалал, тээврийн хэрэгслийн төрлөөр

Тээврийн хэрэгслийн төрөл	Орон нутаг	Нийслэл	Улсын дүнгээр	
	1	Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 34.9%	Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 37.2%	Суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 36.5%
	2	Мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 30.1%	Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 27.9%	Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 21.1%
	3	Ердийн хөсгийн осол /мориноос унах/ 23.7%	Мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 10.6%	Мотоциклтэй зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 16.7%
	4	Явган зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 6.6%	Дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 10.3%	Ердийн хөсгийн осол /мориноос унах/ 14.0%
	5	Ачааны машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж гэмтэх 2.5%	Ердийн хөсгийн осол /мориноос унах/ 9.5%	Дугуйтай зорчигч зам тээврийн осолд орж гэмтэх 7.6%

Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл харьяаллаар харвал Төв аймаг 801 /3.4%/ болон Архангай 776 /3.3%/ хамгийн их тохиолдол бүртгэгдсэн бөгөөд Говьсүмбэр 142 /0.6%/ болон Орхон 169 /0.7%/ аймгууд хамгийн бага бүртгэгдсэн байна. Бүсээр авч үзэхэд Төвийн бүс 2840 /37.8%/ тухайн шалтгаант өвчлөлийн тохиолдол өндөр байна.

Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл харьяаллаар







II БҮЛЭГ

**2023 оны осол гэмтлийн
шалгаант нас баралтын
байдалд хийсэн дүн шинжилгээ**

МОНГОЛ УЛСЫН ОСОЛ ГЭМТЛИЙН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ 2023

2. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

2022 онд гэмтэл хордлого, гадны шалтгаант нас баралт 3353 бүртгэгдсэн нь нийт осол гэмтлийн шинэ тохиолдлын 1.8%-ийг эзэлж байна. Осол гэмтлийн шалтгаант нас баралт өмнөх оноос 0.2%-р өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 10.1 тохиолдол бүртгэгджээ.



Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 78.5% /2427/ нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин эрэгтэйд 14.3 тохиолдол байна.



81.9%

Эрэгтэй


2023 онд согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ осол гэмтэлд өртөж нас барсан 1764 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд түүний 1445 /81.9%/ нь эрэгтэйчүүд байна.



2023 онд гэмтэл хордлого, гадны шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын дундаж нас 42.4, хамгийн багадаа 1 хоногтой нярай, хамгийн ахмад нь 94 настай байжээ.

Дундаж нас	Стандарт хазайлт	Хамгийн бага	Хамгийн их
42.4	16.8	0 /хоног/	94

Гэмтэл хордлого гадны шалтгаант нас баралтыг насны бүлэг тус бүрт бодит тоогоор харвал 45-49 насанд 13.1% /405/ хамгийн их тохиолдол бүртгэгдсэн байна.



2023 онд бүртгэгдсэн осол гэмтлийн шалтгаант нас баралтыг насны бүлгээр өмнөх онтой харьцуулан судлахад 40-44, 65+ насныханд тохиолдлын тоо өссөн үзүүлэлттэй байна. Харин 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 50-54 насанд хамгийн өндөр хэвээр байна.


Насны бүлэг	2021 он		2022 он		2023 он	
	Бодит тоо	Нас баралтын түвшин	Бодит тоо	Нас баралтын түвшин	Бодит тоо	Нас баралтын түвшин
0-4	110	3.0	125	3.3	126	3.4
5-9	55	1.4	42	1.1	43	1.1
10-14	69	2.2	60	1.9	56	1.6
15-19	98	4.5	94	4.3	84	3.6
20-24	165	7.3	144	6.5	114	4.9
25-29	184	7.6	213	9.0	159	6.6
30-34	319	10.9	317	10.8	273	8.9
35-39	357	14.1	391	15.2	340	12.1
40-44	384	17.5	380	17.1	390	16.5
45-49	375	19.0	433	21.6	405	19.1
50-54	346	20.5	405	23.8	385	21.5
55-59	265	18.3	326	22.0	289	19.0
60-64	145	13.5	236	21.5	213	17.9
65-69	75	12.1	114	17.4	126	17.7
70+	79	9.1	73	8.5	89	9.9

2023 оны осол гэмтлийн шалтгаант нас баралтын 73.7% нь санамсаргүй үйлдэгдсэн осол гэмтэл эзэлж байгаа бол 22.7% нь өөрийгөө болон бусдын амь насанд санаатайгаар халдсан тохиолдлууд эзэлж байна. Харин нийт нас баралтын 3.6% нь сэдэл тодорхойгүй нас баралт байна.




Осол гэмтлийн шалтгаант нас баралтын 1-рт санамсаргүй хордох, хорт бодист өртөх **32.8% /1013/**, 2-рт амиа хорлолт **16.2% /502/**, 3-рт зам тээврийн осол **15.4% /477/**, 4-рт байгалийн хүчинд өртөх **8.6% /265/**, 5-рт уналт **7.3% /225/** тус тус тэргүүлж байна.

ГЭМТЭЛ, ХОРДЛОГО ГАДНЫ ШАЛТГААНТ НАС БАРАЛТЫН ТЭРГҮҮЛЭХ 5 ШАЛТГААН:



Тухайн тайлангийн жилд бүртгэгдсэн 1000 шинэ гэмтэл тутамд ногдох үхлийн түвшин усанд живж нас барах, амьсгал боогдох, санамсаргүй хордох, амиа хорлох, байгалийн хүчинд өртөх зэрэг шалтгаанууд /234.1-811.3 тохиолдол/ тэргүүлж байна. Өөрөөр хэлвэл энэ нь усанд живсэн 1000 шинэ гэмтэл тутамд 811.3 тохиолдол нь нас баралтаар төгссөн байна.



Аль ч хүйсэд санамсаргүй хордож нас барсан тохиолдол тэргүүлж байна. Эрэгтэйд санаатайгаар өөртөө гэмтэл учруулах шалтгаан, эмэгтэйчүүдийн дунд зам тээврийн ослын шалтгаан нас баралтын 2-р шалтгаан болж байна.

Нас баралтын тэргүүлэх шалтгаан, хүйсээр




Осол гэмтлийн шалтгаант нас баралтын тэргүүлэх шалтгаан нь насны бүлэг бүрт харилцан адилгүй байна. 2023 онд 0-4 насанд амьсгал боогдох шалтгаант осол, 5-14 насанд зам тээврийн осол, 15-29 насанд амиа хорлолт, 30-69, 70-с дээш насанд санамаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралт тэргүүлж байна.

Насны бүлэг	Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан-2023 он				
	I	II	III	IV	V
0-4 /n=126/	Амьсгал боогдох 35.7%	Зам тээврийн осол 16.7%	Усанд живэх 12.7%	Уналт 11.1%	Хордох 7.1%
5-9 /n=43/	Зам тээврийн осол 25.6%	Хордох 18.6%	Усанд живэх 16.3%	Уналт 11.6%	Түлэгдэлт 7.0%
10-14 /n=56/	Зам тээврийн осол 33.9%	Амиа хорлох 19.6%	Хордох 6.7%	Усанд живэх 6.4%	Байгалийн хүчинд өртөх 4.9%
15-19 /n=84/	Амиа хорлох 41.7%	Зам тээврийн осол 16.7%	Уналт 16.6%	Хордох 11.9%	Усанд живэх 4.8%
20-24 /n=114/	Амиа хорлох 42.1%	Зам тээврийн осол 21.9%	Хордох 10.5%	Уналт 9.6%	Хүчирхийлэл 4.4%
25-29 /n=159/	Амиа хорлох 33.3%	Хордох 23.3%	Зам тээврийн осол 15.1%	Хүчирхийлэл 10.1%	Байгалийн хүчинд өртөх 4.4%
30-34 /n=273/	Хордох 27.8%	Амиа хорлох 26.4%	Зам тээврийн осол 16.8%	Хүчирхийлэл 8.4%	Уналт 6.2%
35-39 /n=340/	Хордох 36.2%	Амиа хорлох 17.1%	Зам тээврийн осол 14.4%	Байгалийн хүчинд өртөх 8.5%	Хүчирхийлэл 7.9%
40-44 /n=390/	Хордох 39.0%	Амиа хорлох 18.5%	Зам тээврийн осол 13.3%	Хүчирхийлэл 7.7%	Байгалийн хүчинд өртөх 8.5%
45-49 /n=405/	Хордох 43.5%	Амиа хорлох 13.6%	Зам тээврийн осол 11.8%	Байгалийн хүчинд өртөх 9.9%	Уналт 7.4%
50-54 /n=385/	Хордох 38.4%	Байгалийн хүчинд өртөх 16.6%	Зам тээврийн осол 13.8%	Амиа хорлох 9.3%	Уналт 6.0%
55-59 /n=289/	Хордох 36.7%	Зам тээврийн осол 14.9%	Байгалийн хүчинд өртөх 11.1%	Хүчирхийлэл 9.7%	Амиа хорлох 8.6%
60-64 /n=213/	Хордох 35.7%	Зам тээврийн осол 17.4%	Байгалийн хүчинд өртөх 11.7%	Уналт 10.3%	Амиа хорлох 7.0%
65-69 /n=126/	Хордох 35.7%	Зам тээврийн осол 15.1%	Амиа хорлох 11.9%	Байгалийн хүчинд өртөх 11.1%	Уналт 7.9%
70+ /n=89/	Хордох 30.0%	Уналт 27.8%	Зам тээврийн осол 17.8%	Амиа хорлох 6.7%	Байгалийн хүчинд өртөх 4.4%

2023 онд гэмтэл хордлого, гадны шалтгааны улмаас 26.2% буюу хамгийн өндөр тохиолдол зуны улиралд нас барсан байна.


Нас баралт бүртгэгдсэн улирал, хувиар



Санамсаргүй хордож нас барсан тохиолдол улирал бүрт тэргүүлэх шалтгаан болж байгаа бол 2-рт зун, намрын улиралд зам тээврийн осол, хавар амиа хорлолт, өвөл байгалийн хүчинд өртөх шалтгаан орж байна.


Бүртгэгдсэн улирал	Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
Өвөл	Хордох 34.3%	Байгалийн хүчинд өртөх 13.6%	Амиа хорлох 14.8%	Зам тээврийн осол 9.9%	Уналт 7.2%
Хавар	Хордох 36.7%	Амиа хорлох 18.0%	Зам тээврийн осол 12.9%	Байгалийн хүчинд өртөх 9.4%	Уналт 7.1%
Зун	Хордох 27.5%	Зам тээврийн осол 20.5%	Амиа хорлох 16.2%	Усанд живэлт 8.5%	Уналт 7.9%
Намар	Хордох 32.8%	Зам тээврийн осол 17.9%	Амиа хорлох 15.8%	Хүчирхийлэл 7.2%	Уналт 6.8%

Нийт осол гэмтлийн шалтгаант нас баралтыг сараар харвал 319 буюу нийт тохиолдлын 10.3% нь 7 дугаар сард нас баржээ.



2022 онд осол гэмтлийн шалтгаант нас баралт бямба гаригт 21.1% /706/-р хамгийн өндөр бүртгэгдэж байсан бол 2023 онд баасан гаригт 16.8% /521/ бусад гаригуудаас өндөр бүртгэгдсэн байна.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт, бүртгэгдсэн гаригаар




2023 онд бүртгэгдсэн нийт осол гэмтлийн шалтгаант нас баралтын 60.2% /1863/ нь нийслэлд, 39.8% /1230/ нь орон нутагт бүртгэгдсэн байна. 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин нийслэлд 11.0, орон нутагт 7.0 тохиолдол байна. Харин 1000 шинэ гэмтэлд ногдох үхлийн түвшин 2023 онд нийслэлд 10.4, орон нутагт 37.9 тохиолдол бүртгэгдсэн байна.

Бүртгэгдсэн газар	Нас баралт		Нас баралтын түвшин	Үхлийн түвшин
	Бодит тоо	Хувиар		
Нийслэл	1862	60.2%	11.0	10.4
Орон нутаг	1230	39.8%	7.0	37.9

Орон нутагт осол гэмтлийн шалтгаант нас баралт 1230 бүртгэгдсэн ба үүнээс Архангай болон Төв аймагт хамгийн өндөр тохиолдол бүртгэгдэж, Говьсүмбэр аймагт 20 тохиолдол буюу бусад аймгуудаас бага бүртгэгдсэн байна.

Нас баралт бүртгэгдсэн байршлыг бүсээр харвал Төвийн бүсэд 417 тохиолдол бүртгэгдсэн нь бусад бүсээс өндөр байна.

Осол гэмтлийн шалтгаант нас баралт, харьяаллаар




Нас баралтын тэргүүлэх шалтгааныг бүртгэгдсэн газраар харвал Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймагт санамсаргүй хордож нас барсан шалтгаан тэргүүлж байгаа бөгөөд Булган, Говь-Алтай, Өвөрхангай, Сэлэнгэ, Хөвсгөл аймагт амиа хорлох шалтгаан тэргүүлж байна. Харин бусад аймгуудад зам тээврийн ослын шалтгаан 1-рт оржээ. Нас баралтын тэргүүлэх шалтгаан тус бүрийг дараах хүснэгтээс харна уу.


Харьяалал	Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан				
	I	II	III	IV	V
Архангай (n=102)	Зам тээврийн осол 29.4%	Хордох 24.5%	Амиа хорлох 20.6%	Байгалийн хүчинд өртөх 5.9%	Уналт 3.9%
Баян-Өлгий (n=46)	Зам тээврийн осол 32.6%	Усанд живэх 19.6%	Амиа хорлох 17.4%	Амьсгал боогдох 8.7%	Уналт 4.3%
Баянхонгор (n=59)	Зам тээврийн осол 28.8%	Амиа хорлох 22.0%	Хордох 22.0%	Байгалийн хүчинд өртөх 13.6%	Хүчирхийлэл 5.1%
Булган (n=54)	Амиа хорлох 29.6%	Зам тээврийн осол 27.8%	Хордох 11.1%	Усанд живэх 9.3%	Амьсгал боогдох 7.4%
Говь-Алтай (n=41)	Амиа хорлох 29.3%	Зам тээврийн осол 19.5%	Хордох 19.5%	Байгалийн хүчинд өртөх 12.2%	Уналт 9.8%
Говьсүмбэр (n=20)	Хордох 30.0%	Зам тээврийн осол 30.0%	Амиа хорлох 20.0%	Усанд живэх 5.0%	Байгалийн хүчинд өртөх 5.0%
Дархан-Уул (n=60)	Хордох 36.7%	Амиа хорлох 20.0%	Зам тээврийн осол 11.8%	Уналт 11.7%	Амьсгал боогдох 10.0%
Дорнод (n=60)	Зам тээврийн осол 26.7%	Уналт 16.8%	Амиа хорлох 15.0%	Хордох 10.0%	Байгалийн хүчинд өртөх 10.0%
Дорноговь (n=85)	Зам тээврийн осол 37.6%	Хордох 20.0%	Амиа хорлох 14.1%	Хүчирхийлэл 7.1%	Амьгүй механик хүчинд өртөх 7.1%
Дундговь (n=22)	Зам тээврийн осол 22.7%	Амиа хорлох 22.7%	Уналт 18.2%	Хордох 13.6%	Түлэгдэлт 9.1%
Завхан (n=33)	Зам тээврийн осол 39.4%	Амиа хорлох 18.2%	Хордох 12.1%	Хүчирхийлэл 12.1%	Уналт 6.1%
Орхон (n=46)	Хордох 30.4%	Уналт 15.2%	Амиа хорлох 10.9%	Хүчирхийлэл 10.9%	Байгалийн хүчинд өртөх 10.9%
Өвөрхангай (n=64)	Амиа хорлох 28.1%	Зам тээврийн осол 23.4%	Хордох 18.7%	Байгалийн хүчинд өртөх 12.5%	Усанд живэх 9.4%
Өмнөговь (n=42)	Зам тээврийн осол 38.1%	Хордох 26.2%	Амиа хорлох 23.8%	Хүчирхийлэл 4.8%	Байгалийн хүчинд өртөх 4.8%
Сүхбаатар (n=53)	Зам тээврийн осол 32.1%	Амиа хорлох 18.9%	Байгалийн хүчинд өртөх 15.1%	Хордох 13.2%	Уналт 13.2%
Сэлэнгэ (n=72)	Амиа хорлох 26.4%	Хордох 22.2%	Зам тээврийн осол 20.8%	Усанд живэх 8.3%	Амьсгал боогдох 6.9%
Төв (n=116)	Зам тээврийн осол 35.3%	Хордох 17.2%	Амиа хорлох 12.9%	Байгалийн хүчинд өртөх 10.3%	Амьсгал боогдох 7.8%
Увс (n=54)	Зам тээврийн осол 31.5%	Амиа хорлох 29.6%	Усанд живэх 14.8%	Хордох 9.3%	Байгалийн хүчинд өртөх 5.6%
Ховд (n=39)	Зам тээврийн осол 46.1%	Амиа хорлох 33.3%	Усанд живэх 7.7%	Хүчирхийлэл 2.6%	Байгалийн хүчинд өртөх 2.6%
Хэнтий (n=75)	Зам тээврийн осол 30.7%	Амиа хорлох 21.3%	Хордох 14.7%	Байгалийн хүчинд өртөх 14.7%	Уналт 4.0%
Хөвсгөл (n=87)	Амиа хорлох 31.0%	Хордох 21.8%	Зам тээврийн осол 18.4%	Усанд живэх 9.2%	Хүчирхийлэл 4.6%
Улаанбаатар (n=1863)	Хордох 42.3%	Амиа хорлох 12.6%	Байгалийн хүчинд өртөх 9.1%	Уналт 8.3%	Хүчирхийлэл 8.2%

2.1 САНАМСАРГҮЙ ХОРДОХ, ХОРТ БОДИСТ ӨРТӨХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /Х40-Х49/

2023 онд улсын хэмжээнд санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралт 1013 тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 16.1%-р буурсан байна. Мөн 10 000 хүн ам тутмын 2.9 тохиолдол санамсаргүй хордож нас барсан бөгөөд энэхүү үзүүлэлт нь өмнөх онтой харьцуулахад 0.7 тохиолдлоор буурсан байна.



Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, хүйсээр




Хордож нас барсан тохиолдлын 75.6%-ийг эрэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд 10 000 хүн тутамд ногдох нас баралтын түвшин 4.5 тохиолдол байна.

Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, эзлэх хувь



Санамсаргүй хордсон шалтгаант нас баралт




Бусад гэмтэл, хордлого, гадны шалтгааны нас баралт

2023 онд нийт гэмтэл, хордлого гаднын шалтгаант нас баралтын 32.8%-ийг санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаан эзэлж байгаа бөгөөд осол гэмтлийн улмаас нас барсан 3 хүн тутмын 1 нь хордолтын шалтгаантай байна.

0% 20% 40% 60% 80%

Санамсаргүй хордсон нас баралт 45-49 насанд тохиолдлын тоогоор өндөр байна. Харин 10 000 хүн амд ногдох нас баралтын түвшин 45-49 нас болон 50-54 нас насанд хамгийн өндөр байна. Бусад насны бүлэгт санамсаргүй хордох, хорт бодист өртсөн тохиолдол харилцан адилгүй бүртгэгдсэн байна.






Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, насны бүлгээр, 10 000 хүн амд



Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанаар нас барсан нийт тохиолдлын **98.9%** нь эмийн бус бодист хордсон байна.



Санамсаргүй хордох, хорт бодист өртөж нас барсан тохиолдлын тэргүүлэх шалтгааныг авч үзвэл **спиртэд санамсаргүй хордсон тохиолдол дангаараа 84.2%**-ийг эзэлж байна.

-  **Х45** Спиртэд санамсаргүй хордох 84.2%
-  **Х47** Бусад хий, ууранд санамсаргүй хордох, өртөх 13.6%
-  **Х49** Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох, өртөх 1.1%
-  **Х44** Бусад ба тодорхойгүй эм, эмийн бэлдмэл, биологийн бодист санамсаргүй хордох, өртөх 0.7%
-  **Х40** Опиоид бус өвчин намдаагч, халуун бууруулах ба хэрлэгийн эсрэг эмэнд санамсаргүй хордох, өртөх 0.3%

Санамсаргүй хордож нас барсан шалтгаан тус бүрийг насны бүлгээр харвал 0-4 насанд Эм, биологийн бэлдмэлд хордох 36.4%, 45-49 насанд Спиртэд санамсаргүй хордох 19.2%, 30-34 насанд Бусад хий, уурт санамсаргүй хордох 10.9%, 15-19 насанд Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох шалтгаанууд тэргүүлсэн байна.


Насны бүлэг	Эм, биологийн бэлдмэлийн хордлого /X40-X44/		Спиртэнд санамсаргүй хордох /X45/		Бусад хий, ууранд санамсаргүй хордох /X47/ (угаарын хийн хордлого, ахуйн газ г.м)		Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох /X49/	
	Нас баралт	Хувь	Нас баралт	Хувь	Нас баралт	Хувь	Нас баралт	Хувь
0-4	4	36.4			5	3.6		
5-9	1	9.1			7	5.1		
10-14					7	5.1	2	18.2
15-19			1	0.1	4	2.9	5	45.5
20-24	2	18.2	6	0.7	4	2.9		
25-29			28	3.3	9	6.5		
30-34	1	9.1	63	7.4	12	8.7		
35-39	2	18.2	106	12.4	15	10.9		
40-44			139	16.3	12	8.7	1	9.1
45-49			164	19.2	12	8.7		
50-54			138	16.2	8	5.8	2	18.2
55-59			94	11.0	12	8.7		
60-64			62	7.3	14	10.1		
65-69			39	4.6	5	3.6	1	9.1
70+	1	9.1	13	1.5	12	8.7		
Нийт	11	100	853	100	138	100	11	100

2023 онд X47- Бусад хий уурт санамсаргүй хордох /угаарын хийн хордлого, ахуйн газанд хордох г.м/ шалтгаант нас баралт өмнөх оноос 30.1%-р өссөн байна. Харин X45- Спиртэд санамсаргүй хордох шалтгаант нас баралт өмнөх оноос %-р буурсан ба бусад шалтгаанууд мөн адил харилцан адилгүй өссөн үзүүлэлттэй байна.



Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаанууд /Х40-Х49/	2019	2020	2021	2022	2023
Х40 Опиоид бус өвчин намдаах, халуун бууруулах ба хэрлэгийн эсрэг эмэнд санамсаргүй хордох	1	0	0	4	3
Х41 Өөр бүлэгт ангилаагүй таталтын эсрэг, тайвшруулах, паркинсоны өвчний эсрэг, сэтгэц нөлөөт эмэнд санамсаргүй хордох	0	0	0	2	0
Х42 Өөр бүлэгт ангилаагүй хар тамхины ба психодислептик эмэнд санамсаргүй хордох				6	1
Х43 Тусгаар мэдрэлийн тогтолцоонд нөлөөлдөг бусад эмэнд санамсаргүй хордох				1	0
Х44 Бусад ба тодорхойгүй эм, эмийн бэлдмэл, биологийн бодист санамсаргүй хордох	6	2	4	5	7
Х45 Спиртэд санамсаргүй хордох	668	651	857	1067	853
Х46 Органик уусгагч, халоген агуулсан нүүрсустөрөгч, тэдгээрийн уураар санамсаргүй хордох	4	0	1	1	0
Х47 Бусад хий, уурт санамсаргүй хордох /угаарын хийн хордого, газ г.м/	50	107	148	106	138
Х48 Хортон шавьж устгах хоронд санамсаргүй хордох	1	1	1	0	0
Х49 Бусад ба тодорхойгүй химийн ба хорт бодисоор санамсаргүй хордох	18	13	7	16	11

Санамсаргүй хордох нас баралт 2022 онд өвлийн улиралд хамгийн их тохиолдож байсан бол 2023 онд хавар хамгийн өндөр бүртгэгджээ. Хүйсийн хувьд авч үзэхэд эрэгтэйчүүд өвлийн улиралд, эмэгтэйчүүд намрын улирал нас барах тохиолдол их байна.

Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, хүйс, улирлаар



2022 онд санамсаргүй хордож нас барсан тохиолдол 2, 12 сард хамгийн өндөр байсан бол 2023 онд 2, 3 сард хамгийн их бүртгэгджээ.




2023 онд нийслэл хотод 787 хүн хордолтын улмаас нас барсан нь өмнөх онтой харьцуулахад 19.0%-р буурсан байна. Харин хөдөө орон нутагт 226 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оноос 4.2%-р буурсан үзүүлэлттэй байна.

Жилд нийслэлийн 10 000 хүн тутмын 4 нь, орон нутгийн 10 000 хүн тутмын 1 нь санамсаргүй хордож нас барсан байна. Мөн 1000 шинэ гэмтэлд ногдох үхлийн түвшин нийслэл хотод 285.9, орон нутагт 204.7 тохиолдол байна.


Бүртгэгдсэн газар	Шинэ тохиолдол	Нас баралт	Хувь	Үхлийн түвшин	Нас баралтын түвшин
Нийслэл	2752	787	77.7%	285.9	4.6
Орон нутаг	1104	226	22.3%	204.7	1.8

Санамсаргүй хордох, хорт бодист өртөх шалтгаант нас баралтын 853 /84.2%-г **X45-** Спиртэд хордох шалтгаан эзэлдэг ба 2023 оны байдлаар Монгол улс сард дунджаар 71.2, өдөрт дунджаар 2-3 хүнээ архины улмаас алдсан байна.




Санамсаргүй хордож нас барсан тохиолдлыг бүртгэгдсэн газраар харвал Архангай аймагт хамгийн их, Ховд аймагт тохиолдол бүртгэгдээгүй байна. Бүсээр авч үзэхэд Хангайн бүсэд тохиолдлын тоо өндөр байна.

Санамсаргүй хордож нас барсан тохиолдол, харьяаллаар



2.2 САНААТАЙГААР ӨӨРТӨӨ ГЭМТЭЛ УЧРУУЛАХ ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /Х60-Х84/


Монгол улсад 2023 онд амиа хорлож нас барсан нийт 502 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 7.7%-р буурсан үзүүлэлттэй байна. Сүүлийн 5 жилийн байдлаар 2022 онд/544/ хамгийн өндөр тохиолдол бүртгэгджээ. Нас баралтын түвшин 2023 оныг 2019 онтой харьцуулахад 0.2 тохиолдлоор өссөн байна.




2023 онд амиа хорлож нас барсан нийт тохиолдлын 87.8% буюу 441 нь эрэгтэй, 12.2% буюу 61 тохиолдол нь эмэгтэйчүүд байжээ. 10 хүн тутмын 8 нь эрэгтэй байна.




2019-2023 онд санаатайгаар өөртөө гэмтэл учруулж нас барсан 2037 эрэгтэй, 341 эмэгтэй бүртгэгдсэн байна. Тухайн шалтгаанаар нас барсан эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 6 дахин их бүртгэгджээ. Нас баралтын түвшин эрэгтэйд эмэгтэйгээс 2-2.4 тохиолдлоор их байна. Амиа хорлож нас барах тохиолдол эрэгтэйчүүдийн дунд ихсэх хандлага ажиглагдаж байна.




Сүүлийн 5 жилийн байдлаар амиа хорлох оролдлого хийсэн 1000 хүн тутмын 379-421 нь нас баралтаар төгссөн байна.



Тухайн шалтгааны нас баралтын тохиолдол 30-34 насанд /72/, 40-44 насанд /72/, нас баралтын түвшин 40-44 насанд /3.0 бусад наснаас өндөр байна. Өөрөөр хэлбэл 40-44 насны 10000 хүн тутамд 3 нь амиа хорлож нас барсан үзүүлэлттэй байна.




Амиа хорлож нас барсан тохиолдол эрэгтэйд 30-34 насанд 67 тохиолдол, эмэгтэйд 40-44 насанд бусад наснаас өндөр бүртгэгдсэн байна. хамгийн бага нас 8, хамгийн өндөр настай 88,



Тэргүүлэх 5 шалтгаан:


- | | | |
|------------|--|-------|
| 1. X70 | Өөрийгөө санаатайгаар дүүжлэх, боймлох, амьсгал боох | 93.1% |
| 2. X78 | Өөрийгөө иртэй зүйлээр санаатай гэмтээх | 2.2% |
| 3. X72-X74 | Өөрийгөө санаатай буудах | 1.8% |
| 4. X80 | Санаатайгаар өөрөө өндрөөс үсрэх | 1.6% |
| 5. X76-X77 | Өөрийгөө санаатайгаар гал, дөл, ууранд түлэх | 0.6% |

2023 онд амиа хорлож нас барсан нийт тохиолдол 28.1% хаврын улиралд бүртгэгдсэн байгаа нь бусад улиралаас өндөр үзүүлэлттэй байна. Тухайн шалтгааны нас баралт орон нутагт өндөр байна.





Орон нутагт Хөвсгөл аймагт бусад аймгуудаас, Хангайн бүс бусад бүсээс амиа хорлож нас барсан тохиолдол өндөр байна.

Амиа хорлож нас барсан тохиолдол бүртгэгдсэн аймаг, бүсээр




2.3 ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ /2023/

2023 онд зам тээврийн ослын улмаас амь насаа алдсан 477 тохиолдол бүртгэгдэж 10'000 хүн амд ногдох нас баралтын түвшин өмнөх оноос 0.1 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.




Зам тээврийн ослоор амь насаа алдсан нийт тохиолдлын 75.5% нь эрэгтэйчүүд, 24.5% нь эмэгтэйчүүд байна.

Зам тээврийн ослын улмаас нас барсан тохиолдлын тоо 50-54 насанд хамгийн өндөр байгаа боловч нас баралтын түвшин 60-64 насанд хамгийн өндөр буюу тухайн насны 10 000 хүн ам тутмын 3.1 нь уг шалтгааны улмаас нас барсан байна.




2023 онд зам тээврийн ослын шалтгаант нас баралтын 32.1% буюу 153 тохиолдол согтууруулах ундаа хэрэглэсэн өгүүлэмжтэй байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ зам тээврийн осолд өртөж нас барсан тохиолдол 2023 онд өмнөх оноос 4.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



2023 онд зам тээврийн ослын улмаас нас барах тохиолдол зун хамгийн их буюу 34.8% бүртгэгдсэн бол намар 28.7%, хавар 21.2%, өвөл хамгийн бага буюу 15.3% бүртгэгдсэн байна.



Сараар авч үзвэл, 7 сард тохиолдлын тоо хамгийн өндөр буюу 67 /14%/ бүртгэгдсэн байна.




2023 онд зам тээврийн ослын улмаас нас барсан тохиолдлыг дараах 5 шалтгаан тэргүүлж байгаа ба суудлын машин дотор явж байсан хүн зам тээврийн осолд орж нас барах тохиолдол хамгийн их буюу 37.9% байна.



Зам тээврийн ослын шалтгаант нас баралтын дийлэнх тохиолдол буюу 72.3% нь орон нутагт бүртгэгдсэн байна.



Тухайн шалтгааны улмаас нас барсан тохиолдлыг гэмтлийн байршлаар авч үзвэл 61.0% /291/-г толгойн гэмтэл эзэлж байна.



Зам тээврийн ослын шалтгаант нас баралт төвийн бүсэд 122 тохиолдол бүртгэгдсэн нь бусад бүсээс өндөр байгаа бол орон нутагт Төв аймагт 41 тохиолдол бүртгэгдсэн нь бусад аймгуудаас өндөр үзүүлэлттэй байна.

Зам тээврийн ослын шалтгаант өвчлөл харьяаллаар

